


2018.11.12-11.17

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд буурсан үзүүлэлттэй байна. Тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон мэдээлэл технологийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш буурсан бол үл хөдлөх хөрөнгө, аж үйлдвэрийн салбарын компаниудын хувьцааны ханш өсчээ.

Даваа гарагт "Amazon.com" компанийн хувьцааны ханш энэ оны 8-р сард хүрсэн дээд үнээс 20 орчим хувиар буурсан байна. "Apple" компанийн ухаалаг гар утасны борлуулалт компани iPhone утасны борлуулалтыг бууруулна хэмээн мэдээлж, "Apple" компанийн хувьцааны ханш унав. Мөн энэ долоо хоногийн сүүлчээр эрүүл мэнд, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч "3M" компани 2019 оны ажлын төлөвлөгөөгөө танилцуулж, улмаар тус компанийн хувьцааны ханш өсчээ.

АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал хөрөнгийн зах зээлд нөлөөлсөн хэвээр байна. Даваа гарагт АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар авто машины импортод гаалийн татвар ногдуулах төслийг бэлдэж байгаа хэмээн мэдэгдэж, хөрөнгийн зах зээлийн индексүүд буурч эхэлсэн. Харин Пүрэв гарагт БНХАУ "Их 20"-ийн чуулганаас өмнө АНУ-тай хэлэлцээ хийх төлөвлөгөөний хувилбарууд боловсруулсан талаар мэдээлэл гарсан. Ингэснээр хөрөнгийн зах зээлийн индексүүд өссөн байна.

10-р сард АНУ-ын түлшний үнэ болон дотоодын хэрэглээний түвшин өсч, тус улсын жижиглэнгийн худалдааны борлуулалт нэмэгдсэн байна. 10-р сард аж үйлдвэрийн гарц таамагласнаас бага хэмжээгээр өссөн үзүүлэлттэй байв. АНУ-ын Хөдөлмөрийн яамны мэдээлснээр суурь инфляцийн түвшин маш бага хэмжээгээр нэмэгджээ.

Хувьцааны зах зээлийн индексүүд болон газрын тосны ханш буурч эхэлснээр хөрөнгө оруулагчид Засгийн газрын бонд ихээр худалдаж авах болсон. Ингэснээр АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж буурсан байна.

Европ: "Brexit" хэлцлийн тодорхой бус байдал болон Италийн төсвийн асуудалтай холбоотойгоор Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд буурсан үзүүлэлттэй байна. Тус бүс нутгийн банкуудын хувьцааны ханш хамгийн ихээр унажээ. Английн фунт ам.долларын эсрэг 1.24%-аар, евро 0.6%-аар суларсан байна.

Их Британийн Ерөнхий сайд Тереза Мэй "Brexit" хэлэлцээрийн төслийг танилцуулахад тус улсын хэд хэдэн сайд нар эсэргүүцэн, огцрохоо мэдэгдсэн билээ. Харин тэрбээр "BREXIT-ийн хэлэлцээрийн төслийг дэмжихгүй бол хэлэлцээр хийхгүйгээр Европын Холбооноос гарна" гэж Парламентын гишүүдэд анхааруулсан байна. BREXIT-ийн хэлэлцээрийн төслийг батлахад Парламентын 650 гишүүний 320-ийнх нь санал хэрэгтэй байгаа ажээ.

Италийн Засгийн газар Европын холбооноос тавьсан төсвийн зардлыг танаж, алдагдлыг бууруулах шаардлагыг биелүүлэхээс татгалзаж, тус улсын хөрөнгийн зах зээлийн FTSE MIB индекс 2%-аар буурч, харин Засгийн газрын үнэт цаасны өгөөжийн түвшин нэмэгдсэн байна.

Япон: Энэ долоо хоногт Японы Nikkei 225 индекс 2.56%-аар буурчээ.

Японы Засгийн газар тус улсын ДНБ энэ оны 3 улиралд 1.2%-аар өссөн талаар мэдээлэв. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8%-аар удааширчээ. Үүнд байгалийн гамшиг, дотоодын хэрэглээний түвшин болоод экспортын хэмжээ буурсан зэрэг үйл явдлууд голчлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,160.25	-1.95% ▼
Dow Jones	АНУ	25,413.22	-16.58% ▼
S&P 500	АНУ	2,736.27	-1.61% ▼
Nasdaq	АНУ	7,247.87	-2.15% ▼
S&P/TSX	Канад	15,155.50	-0.78% ▼
FTSE 100	Их Британи	7,013.88	-1.29% ▼
S&P/ASX 200	Австрали	5,730.60	-3.23% ▼
Nikkei 225	Япон	21,680.34	-2.56% ▼
Hang Seng	Хонг Конг	26,183.53	2.27% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	108.18
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	96.11
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	94.96
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.26
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.59
DBM' 2023	USD	7.250%	98.72
TDBM' 2020	USD	9.375%	105.23

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.300	-0.01 ▼
Libor 3M	2.645	0.03 ▲
Libor 6M	2.863	0.00 ▲
Libor 1YR	3.124	-0.02 ▼
US 6M Bond	3.061	0.55 ▲
US 2YR Bond	2.802	-0.12 ▼
US 3YR Bond	2.845	-0.15 ▼
US 5YR Bond	2.880	-0.16 ▼
US 10YR Bond	2.494	-0.69 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.11.17	Өөрчлөлт
USD	2,574.65	0.30% ▲
CNY	371.09	0.18% ▲
EUR	2,940.25	-0.01% ▼
RUB	39.02	0.41% ▲
KRW	2.30	0.44% ▲
JPY	22.82	0.53% ▲
CAD	1,958.65	0.15% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,221.53	0.88% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	14.40	1.41% ▲
Зэс	USD/lb.	277.40	2.84% ▲
Нүүрс	USD/MT	98.55	-5.78% ▼
WTI газрын тос	USD/bbl.	57.19	-5.88% ▼
Brent газрын тос	USD/bbl.	67.42	-5.07% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	4.64	23.08% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. X	6.30%
Бодлогын хүү	2018. X	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. IX	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. IX	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. IX	5.10%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. IX	17.50%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. IX	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 45 компанийн 1,690.6 сая төгрөгийн 2,625,113 ширхэг хувьцаа арилжигдав.


“Алтайн зам” /AZH/ компанийн хувьцаа 32.19%-аар буюу хамгийн ихээр өсч 30,060 төгрөгт хүрч хаагдсан бол “Монгол нэхмэл” /MNH/ компанийн хувьцаа 14.29%-аар буурч 2,100 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 6,679 ширхэг үнэт цаас 707.4 сая төгрөгөөр арилжаалагджээ

11-р сарын 17-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,380.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,160.25 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.95%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	2,398.0
Зах зээлийн үнэлгээ	2,380,528.1

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,160.25	-1.95% ▼
MSE I индекс	9,694.41	-1.42% ▼
MSE II индекс	8,487.33	-2.64% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Хай Би Ойл	21,497,760	1,053,397,907
АПУ	356,640	209,335,855
Ард даатгал	121,959	91,029,399
Айтүүлс	653,087	72,572,920
ЛэндМН ББСБ	636,887	46,703,702

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Алтайн зам	30,060.00	32.19% ▲
Хуртай	126.50	15.00% ▲
Авто импекс	2,100.00	10.53% ▲
Женко тур бюро	75.00	7.14% ▲
Талх чихэр	20,900.00	4.50% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол нэхмэл	2,100.00	-14.29% ▼
Эрдэнэт авто зам	515.00	-13.45% ▼
Бүтээлч үйлс	1,300.00	-13.33% ▼
Жинст-Увс	1,385.00	-12.62% ▼
Хөх ган	71.00	-11.25% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард капитал групп	2,142,688,228
Мирэ Эссет Секьюритис Монгол	1,355,505,780
Голомт Капитал	282,199,207
Ард секьюритиз	195,324,650
Стандарт инвестмент	160,391,654

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	580.00	617,225
Таван толгой	7,700.00	405,522
Говь	32,540.00	253,849
МИК	11,000.00	227,803
Сүү	227.90	78,398

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-11/04/19-A0230-18	281	28,577,700	101,700	101,700	104	18.000%
2	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	11	1,100,000	100,000	100,000	156	15.140%
3	ZGEB-BD-22/05/20-A0248-15.87	6,000	637,710,000	105,930	106,640	156	15.870%
4	ZGEB-BD-24/10/19-A0348-13.955	387	40,042,890	103,470	103,470	104	13.955%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.01-2018.11.30
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дюти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Цемент шохой” ХК-ийн хаалттай хүрээнд нэмж гаргасан үнэт цаасны арилжааг амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүллээ

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй Хөтөлийн “Цемент Шохой” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6 сая ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд санал болгон гаргахыг СЗХ-ны 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 316 тоот тогтоолоор зөвшөөрсний дагуу тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 2018 оны 10-р сарын 15-ны өдөр явагдаж, нэмж гаргаж буй үнэт цаасыг нэг бүрийг нь 170 төгрөгөөр амжилттай арилжсан болно.

Үүний дагуу, СЗХ-ноос тус компанийн нэмэлт үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг 2018 оны 11-р сарын 15-ны өдрийн 1/4380 тоот албан бичгээр олгосон тул “Цемент шохой” ХК-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс нээлээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” 2018 оны 3-р улирлын санхүү, үйл ажиллагааны тайлангаа нийтэллээ

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX:ERD | MSE:ERDN) нь санхүү, үйл ажиллагааны 3-р улирлын тайлангаа компанийн цахим хуудас болон Канад улсын цахим тайлан мэдээний SEDAR системд нийтэлсэн байна.

Тайлант хугацаанд тус компани нь дараах гол үр дүнд хүрсэн байна. Үүнд:

-Хөндий алтны төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг эхлүүлсэн;

-Хөндий алтны төслийн NI 43-101 стандартын эрдсийн нөөцийн тайланг тайлагнаж, бүртгүүлсэн;

-Баян Хөндий болон Алтан Нарын орд газарт ашиглалтын тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргахад бэлтгэж, холбогдох техникийн судалгаануудыг эхлүүлсэн;

-Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд орших Алтан Сум, Хойд Хөндий талбайд 7 хэтийн төлөвт бүсийг шалгах 3,452 метрийн 25 өрмийн судалгааг хийсэн;

-Монгол улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамнаас сүүлийн 10 жилийн хугацаанд анх удаа зарласан тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад 11-р сарын 14-нд оролцохоор хүсэлт гаргаж, бүртгүүлсэн;

-Компанийн хайгуулын зардал 2017 оны мөн үеэс 42%-иар, захиргаа, удирдлагын зардал 17%-иар, цэвэр алдагдал 14.7 хувиар тус тус буурсан.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

СЗХ: Шинээр гаргах компанийн өрийн хэрэгслийг бүртгэж, хяналт шалгалтын журмыг батлав

Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хуралдаан 11-р сарын 14-ны өдөр боллоо.

Хуралдаанаар, “Минжпропери” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах нэг жилийн хугацаатай 1.0 тэрбум төгрөгийн “Парк Таун” бондыг үнэт цаасны бүртгэлд бүртгэлээ. Тус компани Дархан-Уул аймагт хэрэгжүүлэх Парк Таун-2 төслийнхөө урсгал санхүүжилтийг энэхүү бондоор босгох бөгөөд ирэх онд бондын хоёр дахь хэсгийг хоёр жилийн хугацаатай 2.0 тэрбум төгрөгийн дүнтэйгээр гаргахаар бэлтгэж буй аж. “Парк Таун” бондын арилжааг “Монголын үнэт цаасны бирж” ХК эрхлэн гүйцэтгэх бөгөөд өрийн хэрэгслийн жилийн хүүг арилжааны банкуудын дундаж хадгаламжийн хүү болон Засгийн газрын үнэт цаасны хүүгээс өндрөөр санал болгохоор үнэт цаас гаргагчид төлөвлөжээ.

Мөн Хорооны хуралдаанаар, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг баталлаа. “Уг журамд үнэт цаасны, даатгалын, банк бус санхүүгийн, хадгаламж зээлийн хоршооны болон үл хөдлөх хөрөнгийн худалдаа, зуучлалын салбарт явуулах хяналт шалгалтын ажлын хэлбэр төрөл болон дүгнэлт гаргах, тайлагнах үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилт хангалтгүй буюу зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар нарийвчлан тусгасан байна.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

МХБ: Бүртгэлтэй компаниудаас 28 ХК-д гадаадын нөлөө бүхий хөрөнгө оруулагчид байна

Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй 222 компанийн 28-ынх нь хувьд гадаадын хөрөнгө оруулагчид тус бүр таваас дээш хувийг эзэмшиж байгаа талаар Монголын Хөрөнгийн бирж мэдээллээ.

Өөрөөр хэлбэл энэ оны 9-р сарын эцсийн байдлаар хувьцаат компаниудын 12 хувьд нь гадаадын хөрөнгө оруулагчид том хувьцаа эзэмшигч болжээ. Эдгээрээс онцолбол “Heineken Asia Pacific” компани Монголын хөрөнгийн захад хамгийн их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, АПУ компанийн 25 хувийг эзэмшиж байгаа юм. Мөн АПУ компанийн 14 хувийг “Wit Alliance” компани эзэмшдэг аж.

Түүнчлэн, “Говь” компанийн 34 хувийг Японы хөрөнгө оруулалтын “Hide Inter” компани эзэмшиж байна.

Дотоодод гадаадын үнэт цаасны компаниуд үйл ажиллагаа явуулснаар гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж байгааг Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Лхагвасүрэн мэдээлж байв. Мөн БНСУ, Японы хөрөнгө оруулагчид Монголын зах зээлийг сонирхох болсныг онцолж байна.

Сүүлийн нэг жилийн хугацаанд дотоодын хөрөнгийн захад долоон компани шинээр бүртгүүлж, нэг компани нэмж хувьцаа гаргах замаар 33 тэрбум гаруй төгрөгийг татан төвлөрүүлээд байгаа аж. Үүнээс 10 гаруй хувийг гадаадын хөрөнгө оруулагчид оруулсан талаар Монголын Хөрөнгийн бирж мэдээллээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Нүүрсний экспорт 10 хувиар өсөж, 31.3 сая тонн болов

2018 оны эхний 10 сард нийт экспортын 41 хувийг нүүрсний экспорт дангаараа бүрдүүлсэн байна. Нийт 2.4 тэрбум ам.долларын 31.3 сая тонн нүүрсийг Монгол Улс экспортолсон талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ.

Компаниудаас “Эрдэнэс Тавантолгой” ХК 10-р сарын 8-ны өдрийн байдлаар 7.78 сая тонн нүүрс олборлож, 10 сая тонныг борлуулжээ. Тус компани нүүрсний олборлолтоо энэ онд 13 сая тонн, ирэх онд 15 сая тонн, 2020 он гэхэд 20 сая тоннд хүргэх чиглэлтэй байгаа аж. “Эрдэнэс Тавантолгой” компани одоогоор Зүүн Цанхийн нүүрсийг нэг тонныг нь 68 орчим ам.доллараар, Баруун Цанхийн нүүрсийг 70 гаруй ам.доллараар борлуулж байна.

Нарийнсухайтын бүлэг ордод олборлолт хийж буй компаниудаас МАК, “Southgobi Sands” баяжуулах үйлдвэрээ ашиглалтад оруулаад байгаа юм. “Southgobi Sands” л гэхэд 10-р сараас хойш 100 мянган тонн баяжуулсан нүүрс гаргаад байна. Нэг тонн сул коксжих нүүрсийг дунджаар 280 юаниар, эрчим хүчний нүүрсийг 170 юаниар борлуулж байна.

Харин “Өсөх зоос” ХХК-ийн баяжуулах үйлдвэр ирэх онд ашиглалтад орно. Тус компани энэ жил гурван сая тонн нүүрс экспортолохоор төлөвлөснөөс оны эхний 10 сард 2.3 сая тонныг экспортолжээ. Тус компани сул коксжих болон эрчим хүчний нүүрс гаргаж байгаа бөгөөд нэг тонн эрчим хүчний нүүрсний хилийн үнэ 300 юань болсон талаар мэдээллээ.

Монгол Улс ирэх онд 42 сая тонн нүүрс экспортлохоор зорьж байна. Энэ нь боломжтой гэж нүүрс экспортлогчид үзэж байгаа юм. Тухайлбал, “Southgobi Sands” зургаан сая тонн, “Өсөх зоос” ХХК дөрвөн сая тонн нүүрс экспортлох боломжтой гэж мэдээллээ. Гол бэрхшээл нь хил дээр саатал гарч болзошгүй байгаа аж.

Монголын нүүрсний экспортын 50 орчим хувийг гаргадаг Гашуунсухайт-Ганцмодны боомтын тээвэр өнгөрсөн баасан гарагт бүрэн зогссон ч түүнээс хойш сэргээд байна. 9-р сараас хойш зарим үед өдөрт 1,500 автомашин нүүрс гарч байсантай харьцуулахад гурав дахин буураад байгаа юм. БНХАУ-ын тал “Техникийн шинэчлэл хийж байгаа” гэсэн тайлбар өгсөн талаар Гашуунсухайт боомтын захиргаа мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Гашуунсухайт боомт: XI/17-ны 17:00 цаг хүртэл нүүрсний 7-8 автомашин нэвтрэв

Бямба гарагийн 17.00 цагийн байдлаар Гашуунсухайт-Ганцмод боомтоор нүүрсний 7-8 автомашин гарсан, 80 автомашин боомт хоорондын зам дээр боомтоор нэвтрэхээр хүлээж байгаа гэж Гашуунсухайт боомтын захиргаа мэдээллээ.

Мөн “Оюу Толгой”-ийн 32 автомашин гарахаар хүлээж байгаа гэсэн мэдээллийг боомтын захиргаа мөн өгөв. БНХАУ-ын тал бүх автомашиныг бүртгэлжүүлж ухаалаг систем нэвтрүүлж байгаа гэсэн шалтгаанаар татан авалтаа эрс бууруулсан юм. Баасан гарагт нүүрсний 60 автомашин боомтоор гарсан, “Оюу Толгой”-ийн ямар ч экспорт хийгдээгүй байна. Баасан гарагт “Оюу Толгой”-ийн зэсийн баяжмал, Тавантолгойн нүүрсний экспорт бүрэн зогсжээ. БНХАУ-ын тал гаалийн бүртгэлийн системдээ шинэчлэл хийж байгаа гэсэн шалтгаанаар ийнхүү урьдчилан мэдэгдээгүй гэнэт зогсоосон гэдгийг Гашуунсухайт боомтын захиргаа мэдээлсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

БНХАУ-ын шийдвэрийн улмаас Австралид дулааны нүүрсний ханш огцом уналаа

БНХАУ-ын Засгийн газар эх газрын хилийн боомтуудад нүүрсний импортын бүрдүүлэлтийг зогсоох шийдвэр гаргаснаас шалтгаалаад Австралид дулааны нүүрсний ханш 30 гаруй хувиар огцом уналаа. БНХАУ-д нийлүүлэлт хийх ханш хоёрдугаар сард тонн тутамд 90 ам.доллар байсан бол 60 ам.доллар болж буураад байна. Учир нь БНХАУ-ын нүүрсний импорт хязгаарлагдсан нь Австралийн нүүрсний зах зээлд тодорхойгүй байдал үүсгээд байгаа юм. Онцгой хүйтэн өвөл болж цахилгаан станцуудын хэрэглээ нэмэгдэхээс нааш БНХАУ-д дулааны нүүрс импортоор авах шаардлага ойрын хэдэн сардаа үүсэхгүй, тус улсын зах зээлд нийлүүлэлт илүүдэлтэй байгаа гэж “Platts Coal”-ийн тайланд дурджээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Газрын тосны зах зээлд нийлүүлэлт хангалттай түвшинд хүрснийг IEA таатай хүлээн авав

Газрын тосны зах зээлд нийлүүлэлт хангалттай хэмжээнд хүрснийг таатай хүлээн авч байгаагаа Олон улсын эрчим хүчний агентлаг илэрхийллээ.

ОПЕК гарцаа нэмснээр улс орнуудын газрын тосны нөөц ихсэж, улмаар ханш буурсан гэсэн цаг үеийн нөхцөл байдлыг Олон улсын эрчим хүчний агентлаг сарын тайландаа онцолжээ. Аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад сүүлийн дөрвөн сар дараалан газрын тосны нөөц өссөн байна. Хэрэв цаашид гарц өнөөдрийн түвшинд хэвээр байвал дараагийн хагас жил нөөц өдөрт хоёр сая баррелиар нэмэгдэх төлөвтэй байгаа ажээ. Олон улсын эрчим хүчний агентлаг хөгжиж буй орнуудад ирэх онд газрын тосны эрэлт өмнө нь таамаглаж байснаас илүү бага хувиар өсөх төлөвтэй болсныг мөн онцоллоо. Энэ хүрээнд эрэлтийн төлөвийг бууруулж, өдөрт 1.1 сая баррелиар эрэлт өснө гэж тооцоолсон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Southgobi Resources”-ийн борлуулалт III улиралд 21 хувиар өсөв

Хонгконгийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Southgobi Resources” компани энэ оны III улиралд 24.5 сая ам.долларын орлого олсон нь өнгөрсөн оны мөн үеэс 21 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд нийт 700 мянган тонн нүүрс борлуулсан нь жилийн өмнөхтэй харьцуулахад 100 мянган тонноор бага боловч нэг тонн нүүрсний дундаж ханш нь 35 хувиар өсөж, 35.8 ам.доллар болсон байна. БНХАУ-ын нүүрсний зах зээлийн нөхцөл байдал сайжирсан нь үүнд нөлөөлсөн гэж “Southgobi Resources” компани мэдээллээ. Улмаар өнгөрсөн оны мөн үед 4.7 сая ам.долларын алдагдал хүлээж байсан бол энэ III улиралд компани үйл ажиллагаанаасаа 1.7 сая ам.долларын ашиг олсон байна. III улиралд Овоот толгойн уурхай дэх угаах үйлдвэрийн барилгын ажил бүрэн дуусаж, аравдугаар сард үйл ажиллагаагаа эхэлсэн юм. Тус компани угаасан нүүрсээ борлуулж эхлээд байна. 2019 онд энэ үйлдвэрт 1.8 сая тонн нүүрс угааж боловсруулахаар төлөвлөж байгаа ажээ. Үүнээс гадна шүүхийн маргаан гараад байна. Тодруулбал, есдүгээр сард “Southgobi Resources”-ийн охин компани болох “Inner Mongolia Southgobi Energy” компанийн эсрэг ӨМӨЗО-ы Эннээ хошууны Ардын шүүхэд зарга үүсгэсэн байна. БНХАУ-ын “Jiaunguan Xiuyan Trading” компани нүүрсний борлуулалттай холбоотой 19.4 сая юанийн төлбөр нэхэмжилжээ. Энэ шүүх хурлын товыг хойшлуулаад байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

ҮСХ: Монгол улсын эдийн засгийн 10-р сарын байдал

ДНБ

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны эхний 9 сард урьдчилсан гүйцэтгэлээр 12.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.8 (6.4%) их наяд төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 349.2 (7.0%) тэрбум төгрөг (бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртөг 88.5 (6.5%) тэрбум төгрөг), бүтээгдэхүүний цэвэр татвар 305.5 (22.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

ДНБ, оны үнээр 2018 оны эхний 9 сард урьдчилсан гүйцэтгэлээр 23.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.1 (15.1%) их наяд төгрөгөөр өслөө. Улирлын нөлөөллийг арилган тооцсоноор ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 0.8 хувиар өслөө.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр 2018 оны эхний 9 сард урьдчилсан гүйцэтгэлээр 22.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.9 (14.7%) их наяд төгрөгөөр өслөө. Харин эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 12.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.8 (6.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Уг өсөлтөд хөрөнгийн нийт хуримтлал 1.4 (35.7%) их наяд төгрөг, бараа, үйлчилгээний экспорт 1.2 (12.7%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөнгө, зээл

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2018 оны 10 дугаар сарын эцэст 18.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 391.3 (2.2%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.8 (26.1%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2018 оны 10 дугаар сарын эцэст 887.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 41.3 (4.4%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 55.7 (6.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 10 дугаар сарын эцэст 16.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 105.8 (0.6%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.1 (22.9%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 10 дугаар сарын эцэст 1.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 51.8 (5.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 73.7 (7.6%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.3 хувийг эзэлж, өмнөх сараас 0.2 пунктээр өсөж, өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр буурчээ.

Төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны эхний 10 сард 8.3 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 7.2 их наяд төгрөгт хүрлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2017 оны эхний 10 сард 669.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байсан бол 2018 оны эхний 10 сард 341.9 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Энэ оны 10 дугаар сард өмнөх сараас улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 303.2 тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 33.9 тэрбум төгрөгөөр өслөө.

Татварын нийт орлого 6.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (32.2%) их наяд төгрөгөөр өсөхөд тусламжийн орлого 18.5 (44.4%) тэрбум төгрөг, тусгай зориулалтын орлого 0.1 (0.6%) тэрбум төгрөг, хөрөнгийн орлого 0.2 (28.2%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч нэмэгдсэн өртгийн албан татвар 444.2 (33.9%) тэрбум төгрөг, орлогын албан татвар 427.3 (32.2%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 245.3 (23.6%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 210.9 (51.4%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 147.9 (36.4%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 145.0 (30.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 81.3 хувийг татварын орлого, 9.7 хувийг татварын бус орлого, 6.8 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 2.3 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Гадаад худалдаа

Монгол Улс 2018 оны эхний 10 сард 153 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 10.8 тэрбум америк доллар, үүнээс экспорт 5.9 тэрбум америк доллар, импорт 4.9 тэрбум америк долларт хүрлээ. Харин 2018 оны 10 дугаар сард экспорт 662.0 сая америк долларт, импорт 524.5 сая америк долларт хүрч, өмнөх оны мөн үеэс экспорт 56.0 (9.2%) сая америк доллараар, импорт 140.4 (36.5%) сая америк доллараар тус тус өссөн байна.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 (24.4%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 755.9 (14.6%) сая америк доллараар, импорт 1.4 (39.0%) тэрбум америк доллараар тус тус өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2017 оны эхний 10 сард 1.7 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2018 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеэс 610.8 (36.4%) сая америк доллараар буурч, 1.1 тэрбум америк долларт хүрчээ. Гадаад худалдааны тэнцэл 2018 оны 10 дугаар сард 137.5 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 84.4 (38.0%) сая америк доллараар буурсан байна.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 10 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 1.0 хувиар өсөж, өмнөх оны эцсээс 5.6 хувь, өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 5.4 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 4.9 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 9.0 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.1 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 8.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.0 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 14.7 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 10 дугаар сард өмнөх оны эцсээс 5.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 5.3 хувь (мах, махан бүтээгдэхүүн 18.8 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 7.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

мэдэгдэл

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.